

БАТЛАВ.  
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА




Ж.ЦОЛМОН

НОТЛОХ БАРИМТЫГ ХАМГААЛАХ,  
ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

Баримт бичгийн код	АХОЗШША - 25-08		
Баталсан огноо:	2025 он- 11 сар- 15 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр Х. Наранхүү	Огноо 2025. 11. 14	Гарын үсэг 
Боловсруулсан:	Албан тушаал, нэр У. Шинэбаяр	Огноо 2025. 11. 14	Гарын үсэг 

### Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Шинэ хууль, дүрэм	Бүгд	Шинжлэн шалгагч	2025. 11.04	
2					
3					

### Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1	Журам	Шинжлэн шалгагч нарт
2		
3		

## НОТЛОХ БАРИМТЫГ ХАМГААЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсын нутаг дэвсгэр дээр гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийн үед ослын газрын нотлох баримтыг хамгаалах, тээвэрлэх, хадгалах ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Агаарын хөлгийн осол, зөрчил нутаг дэвсгэр дээр нь гарсан улс нь тухайн агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүнийг шинжлэн шалгах ажиллагааны явцад хамгаалах, эд мөрийн нотлох баримтыг найдвартай хадгалах хариуцлага хүлээнэ.

1.3. Энэхүү журмыг агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааны зааврын 5 бүлгийн заалтыг үндэслэн осол, зөрчил гарсан үед ослын газар дээрх агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн, нотлох баримтыг хамгаалалтад авах, цаашдын эвдрэл гэмтэл, зөвшөөрөлгүй хүн нэвтрэх, хулгайд алдах, муутгахын эсрэг хамгаалалт гаргах, тээвэрлэх, хадгалах ажиллагаанд дагаж мөрдөнө.

1.4. Агаарын хөлгийн ослын газар ослын үлдэгдлийг оролдсоны улмаас чухал эд мөрийн баримт алдагдахаас сэргийлэхийн тулд шинжлэн шалгах алба нь орон нутгийн онцгой байдал ба цагдаа, эрэн хайх зэрэг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

1.5. Агаарын хөлгийн ослын газарт хамгийн түрүүнд ирсэн хүмүүсийн нэн тэргүүний зорилго нь амьд үлдэгсдийг аврах ба тэдэнд туслах мөн боломжийн хирээр өмч хөрөнгийг хамгаалахад оршино.

1.6. Тохиолдол болсон улс эд мөрийн/нотлох баримтыг хамгаалах ба шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай байж болох хугацаанд агаарын хөлөг болон түүний нөхцөл байдлыг аюулгүй байлгах үүднээс бүх боломжит арга хэмжээг авна. Эд мөрийн баримтыг устаж үрэгдэх, хөдөлгөх, хулгайлагдах, зөвшөөрөлгүй хүн орохоос хамгаалах ба эд мөрийн/нотлох баримтыг гэрэл зургаар баталгаажуулах арга хэмжээг авна.

### Хоёр. Ослын газар дээрх нотлох баримтыг хамгаалах

2.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах эрх бүхий байгууллагын шинжлэн шалгагчид нь ослын газар нэвтрэх бүрэн эрхтэй байх ба үзлэг шалгалт хийх, агаарын хөлгийн холбогдолтой материалыг шалгах, тэр дундаа бодит хяналтын төхөөрөмж, нислэгийн хөдөлгөөний бичлэг зэргийг хяналтдаа авах эрхтэй.

2.2. Осол гарсан тохиолдолд нислэгтэй холбоотой гэж үзсэн бүх агаарын хөдөлгөөний үйлчилгээний харилцаа холбооны бичлэг, баримт бичгийг аюулгүй байлгаж, шинжлэн шалгах байгууллагаас нэмэлт зааварчилгаа авах хүртэл аюулгүй хадгалах журмыг хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн агаарын хөлөг, нисэх баг болон нислэгийн үйл ажиллагаатай холбоотой агаарын хөлгийн операторын бүх баримт бичгийг нэн даруй авч, аюулгүй хадгалахын тулд урьдчилан зохицуулалт хийх шаардлагатай.

2.3. Агаарын хөлгийн ослын талаар мэдсэн даруйдаа цаг агаарын тусгай тайланг авахын тулд нисэхийн цаг уурын байгууллагуудтай хамтарч ажиллах, нөөц эсвэл шатахуун түгээх цэгүүдээс түлшний дээж авахын тулд түлшний компаниудтай мөн хамтарч ажиллана.

2.4. Осол, зөрчил гарсан нутаг дэвсгэр, ослын газар, эд мөрийн нотлох баримтыг хамгаалалтад авах ажиллагааг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар"-ын 5.1 дугаар бүлэгт заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

2.3. Ослын газарт янз бүрийн шалтгаанаар ослын эд мөрийн баримтууд арилж бүдгэрэх, устаж алга болдог тул ослын газрыг тусгаарлах, гаднын нөлөөнөөс хамгаалах болон шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд шинжлэн шалгах баг нь ослын газарт аль болох түргэн хүрэлцэн очиж шинжлэн шалгах ажиллагааг нэн даруй эхлэх шаардлагатай бөгөөд тодорхой төлөвлөгөөний дагуу ажиллагаануудыг цаг алдалгүй гүйцэтгэж зохион байгуулалтын бэлэн байдалд ажиллах ёстой. Үүнд:

2.3.1. Онцгой байдлын зохицуулалтын төвд мэдэгдэх,

2.3.2. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах эрх бүхий байгууллага ба шаардлагын дагуу бусад эрх бүхий этгээдүүдэд мэдэгдэх,

2.3.3. Ослын үлдэгдлийг галын аюул ба нэмж гэмтэхээс сэргийлэх,

2.3.4. Цацраг идэвхт ачаа юм уу хор зэрэг аюултай барааг тээвэрлэж явсан эсэхийг нягталж зохих арга хэмжээг авах,

2.3.5. Ослын үлдэгдлийг оролдох юм уу үймүүлэхээс сэргийлэх харуул гаргах,

2.3.6. түр зуурын эд мөрийн баримтыг фото зураг болон бусад зохих арга хэрэгслийн тусламжтайгаар хадгалах арга хэмжээ авах,

2.5. Агаарын хөлгийн ослын газар ослын үлдэгдлийг оролдсоны улмаас чухал эд мөрийн баримт алдагдахаас сэргийлэхийн тулд шинжлэн шалгах алба нь орон нутгийн онцгой байдал ба цагдаа, эрэн хайх зэрэг холбогдох байгууллагуудтай хамтарч шинжлэн шалгах ажиллагааны явцад ослын газрын хяналтыг тогтооно.

2.6. Агаарын хөлгийн нислэгийн өгөгдөл бичигч төхөөрөмжүүдийг зөвхөн бичлэг тайлагч мэргэжлийн хүнд хүлээлгэн өгөх хүртэл төхөөрөмжүүдийг бүрэн хамгаалалтад байлгана.

2.7. Хэрэв агаарын хөлгийн бүртгэсэн улс, ашиглагч улс, тээвэрлэгч, үйлдвэрлэсэн улсаас агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн хэсэгт тэдгээр эрх бүхий байгууллагын төлөөлөгчид хүрэлцэн ирэх хүртэл ослын газар ямар нэг үйлдэл хийгүй байхыг хүссэн хүсэлт гаргавал нутаг дэвсгэрт нь осол, зөрчил гарсан улсын холбогдох байгууллагын эрх бүхий этгээд энэ хүсэлтийг биелүүлэх арга хэмжээ авна.

2.8. Галын болон бусад аюулаас хүний амь аврах, амьтан аврах, шуудан тээвэр, үнэт зүйлсийг устгагдахаас сэргийлэх, агаарын навигацийн саатал, бусад төрлийн тээврийн хэрэгсэлд аюул учруулахаас сэргийлэх зэрэг зайлшгүй тохиолдолд нэн даруй тусламж үзүүлнэ.

2.9. Агаарын хөлгийн ослын газар ажиллаж байгаа хүмүүс осол, гэмтэл авах магадлал өндөр байдаг ба ослын газарт аливаа ажлыг эхлэхийн өмнө оролцох хүмүүсийн аюулгүй байдлыг хангах талаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар"-ын 5.6 дугаар бүлэгт заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

2.10. Шинжлэн шалгах үйл ажиллагааны дүрмийн дагуу осол болсон тохиолдолд, тухайн нислэгтэй холбоотой байж болох бүх нотлох баримт, агаарын хөдөлгөөний үйлчилгээний холбооны ярианы бичлэг ба бичиг баримтуудыг шинжлэн шалгах багийн ахлах шинжлэн шалгагчаас цаашид хэрхэх талаар зааварчилгаа авах хүртэл хамгаалж, найдвартай хадгална. Үүнд: агаарын хөлөг, нисэх баг, нислэгийн ажиллагаа мөн нислэгийн цаг уурын мэдээлэлтэй холбоотой тээвэрлэгчийн бичиг баримт орно.

2.11. Эдгээр арга хэмжээнүүдээс гадна, ослын үлдэгдлийг шинжилгээний баг иртэл оролдохгүй байлгах. Цагдаагийн ба аврах албаныханд боломжтой бол агаарын хөлгийн томоохон хэмжээний осолд амь үрэгдсэн хүмүүсийн цогцсыг сүйрлийн хохирогчдыг тогтоох баг ба шинжлэн шалгах баг ирж шалган тэмдэглэл хөтлөх хүртэл байранд нь байлгах шаардлагатай талаар онцлон анхааруулах ёстой. Үүнтэй нэг адилаар хувийн эд зүйлс нь хохирогчдыг таних ажиллагаанд тус болж болох учраас хөдөлгөж болохгүй. Ослын үлдэгдлийг амьд үлдэгдэгсдийг аврах, гал унтраах, олон нийтийг хамгаалахаас өөр зорилгоор оролдох ёсгүй.

2.12. Шинжлэн шалгагчид нь аврах ажиллагааны үеэр ослын үлдэгдлийг оролдсон байсан эсэхийг тогтоох ёстой ба оролдсон тохиолдолд энэ талаар тэмдэглэл хөтлөх ёстой.

2.13. Анхны аврах ажиллагааг дууссаны дараа аврах ажилтнууд өөрсдийн хөдөлгөөн нь шинжлэн шалгах ажиллагаанд хэрэгтэй байж болох эд мөрийн баримтыг устгахгүй байхад аль болох анхаарах ёстой.

2.14. Шинжлэн шалгах багийн ахлах шинжлэн шалгагч нь нь ослын талаар мэдээ авсан даруй ослын үлдэгдлийн хамгаалалтын талаар арга хэмжээ авсан эсэхийг нягталж, харуул хамгаалалтын зохион байгуулалтыг шалгана. Үүнийг голдуу цагдаагийн байгууллагаар дамжуулж хэрэгжүүлдэг боловч зарим тохиолдолд цэргийн ажилтнууд юм уу тусгайлан дайчилсан иргэдийг ашиглаж болно.

2.15. Агаарын хөлөг нь цацраг идэвхт бодис, тэсрэх материал, зэр зэвсэг, идэмхий шингэн, шингэн юм уу хатуу хор, бактери зэрэг аюултай бараа тээвэрлэж явсан талаарх сэжиг таамаг байгаа үед харуул хамгаалалтын хүмүүсийг ослын үлдэгдлээс аюулгүй зайд байрлуулах тусгай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ёстой. Аюултай байж болох бүсүүдэд тэдгээрийн аюулын хэмжээг мэргэжилтнүүд нарийн үнэлэх хүртэл таних тэмдэг тавих шаардлагатай.

2.16. Харуулууд нь өөрсдийн дараах үүрэг хариуцлагыг гүнзгий ухамсарласан байх ёстой. Үүнд: ослын үлдэгдлийн аюулаас олон нийтийг хамгаалах, ослын үлдэгдлийг оролдохоос сэргийлэх, өмч хөрөнгийг хамгаалах, ослын газарт зөвхөн агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах эрх бүхий

байгууллагын зөвшөөрсөн хүмүүсийг нэвтрүүлэх ба боломжтой нөхцөлд агаарын хөлгийн газар дээр гаргасан мөрийг хамгаалж хадгалах,

2.17. Шинжлэн шалгах багийн ахлах шинжлэн шалгагчийн зүгээс ослын газрын харуул хамгаалалтын ажилтнуудад зөвшөөрөл бүхий хүмүүс нь зохих таних тэмдэгтэй байх ёстой талаар тодорхой зааварчилгаа өгөх ёстой. Томоохон шинжлэн шалгах ажиллагааны үед үүнийг бүх зөвшөөрөлтэй хүмүүст энгэрийн тэмдэг юм уу ямар нэг төрлийн нэвтрэх үнэмлэх өгөх замаар шийдэж болно. Харъяаллыг харуулсан бугуйн таних тэмдэг юм уу хүрэм ч байж болно.

2.18. Шинжлэн шалгах багийн ахлах шинжлэн шалгагч нь ослын үлдэгдэл тарж алга болохоос хамгаалж ослын газрыг тойруулан олс татах замаар үр дүнтэй хамгаалалтыг хэрэгжүүлэхэд анхаарах ёстой. Гэхдээ ослын үлдэгдлийн тархалтын сунац нь урт бол хамгаалалтын ажил нүсэр бөгөөд олон тооны харуул шаардлагатай болж болно.

2.19. Орон нутгийн оршин суугчидтай холбоотой ажиллах ялангуяа ослын үлдэгдлийн хол шидэгдсэн хэсгүүдийг олж тогтооход цагдаагийн байгууллага ихээхэн туслалцаа үзүүлж болно. Ойр орчимд амьдардаг хүмүүсийг агаарын хөлгийн ослын үлдэгдлийг илрүүлсэн бол мэдэгдэхэд урамшуулахын зэрэгцээ тэдгээр хэсгүүдийг хөдөлгөхгүй байхын чухлыг тэдэнд мөн ойлгуулах шаардлагатай.

2.20. Хариуцсан шинжлэн шалгагч ослын газраас бүх эд мөрийн баримтыг цуглуулсан гэж үзэх хүртэл ослын үлдэгдлийг хамгаалалтанд байлгах ёстой. Шинжлэн шалгах багийн ахлах шинжлэн шалгагч нь байдлыг тогтмол шалгаж шаардлагын дагуу харуул хамгаалалтын хүчийг нэмэгдүүлэх ёстой.

2.21. Хэрэв ослын үлдэгдэл усан дотор байна гэдгийг мэдсэн даруй олдох боломжтой мэргэжлийн туслалцааг авахын тулд хүчин чармайлт тавин ажиллах ёстой. Ослыг шинжлэн шалгах алба нь усан дор байгаа ослын үлдэгдлийг цаг алдалгүй олж илрүүлэхийн тулд өөрийн онцгой байдлын аврах алба ба бусад байгууллагууд мөн Монгол улсын гадна байгаа эх үүсвэрүүдэд хандах ёстой.

2.22. Хэрэв ослын үлдэгдэл усан дотор байгаа тохиолдолд тухайн хамгаалалтад авах ажиллагааг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар"-ын 5.4 дүгээр бүлэгт заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

2.23. Осол болсон газрын нөхцөл байдал ба байрлал, ослын үлдэгдэл нь шинжлэн шалгах ажиллагаанд шаардагдах чухал эд мөрийн баримтыг агуулж байгаа гэж үзвэл ослыг шинжлэн шалгах эрх бүхий байгууллага нь ослын үлдэгдлийг түргэн шуурхай баталгаажуулан зохих арга хэмжээг авна.

2.24. Ослын үлдэгдлийг хөдөлгөх, чөлөөлөх арга хэмжээг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар"-ын 5.5.8 дугаар бүлэг, холбогдох хууль дүрмийн дагуу хийж гүйцэтгэнэ.

2.25. Агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг хамгаалалтаас чөлөөлөхдөө цаашид шинжлэн шалгах ажиллагаанд

шаардагдахгүй бол бүртгэсэн улс болон ашиглагч улсад буцаана. Хэрэв бүртгэсэн болон эзэмшигч улс нь энэхүү агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн хэсгүүд нь хүрж авах боломжгүй бол боломжит газар байрлуулна.

### **Гурав. Осол, зөрчлийн нотлох баримтыг цуглуулах, тээвэрлэх**

3.1. Ослын шалтгааны хүчин зүйлүүдийг тодорхойлох нь цуглуулсан бүх мэдээлэлд нарийн зөв шинжилгээ хийснээс шалтгаалдаг учраас эд мөрийн баримтыг цуглуулах, бүртгэх, тээвэрлэх үйл явц нь шинжлэн шалгах ажиллагааны хамгийн чухал хэсэг байдаг.

3.2. Шинжилгээнд шаардлагатай эд мөрийн баримтын шинж чанар, тоо хэмжээ нь ихээхэн өөрчлөгддөг болохоор их хэмжээний эд мөрийн баримтыг цуглуулахын тулд өөрийн дадлага туршлага, мэдлэгийг ашиглах ёстой.

3.3. Осол болсон даруйд эд мөрийн баримтыг цуглуулж хадгалж эхлэх бөгөөд уг арга хэмжээг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар"-ын 5.5.7 дугаар бүлэгт заасан зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

3.4. Шинжлэн шалгах ажиллагааны явцад цуглуулсан аливаа эд мөрийн баримтыг нарийн зөв тодорхойлж бүртгэх журмыг тогтооно. Боломжтой үед дараа нь эд ангийг хялбархан танихын тулд өөр дээр нь давхардуулалгүй мөн арилахааргүй тэмдэг тавигдана.

3.5. Бүртгэлийг тэмдэглэл юм уу ном хэлбэрээр хийж хадгалах бөгөөд доорх мэдээллүүд багтсан байна. Үүнд :

- Ослын /файл/ дугаар
- Тодорхойлолт ба системийн таних тэмдэг
- Маяг ба серийн дугаар
- Олдсон байрлалын солбилцол
- Тохиргоо, нэмэлт, олдох үеийн байдал
- Амархан устах тэмдэглэгээний тодорхойлолт

3.6. Эд ангиуд болон хэсгүүдийг даавуу юм уу бусад тохиромжтой материалд ороож, нэмж гэмтэхээс сэргийлэн хайрцагт хийж тээвэрлэнэ.

3.7. Эд ангиудын тохируулга, байрлал эсвэл сунгалтыг тодорхойлж бүртгэхийн тулд:

- Эд ангийг шошго нь нүдэнд харагдахуйцаар гэрэл зургийг нь авна. Эд ангийн гэрэл зургийг авахдаа дараа нь шинжилгээнд хэрэглэхийн тулд туузан метр юм уу бусад хэмжээтэй хэмжих хэрэгслийг тухайн эд анги дээр юм уу түүний хажууд байрлуулна.
- Тохируулга юм уу сунгалтыг тэмдэглэнэ.
- Тохируулга юм уу сунгалтыг бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.

3.8. Гидравлик домкрат, карбюратор, шүүлтүүр зэрэг бохирдсон байж болох эд ангиудын амсрыг бөглөн лацадна. Лацадсан саванд хадгалж тээвэрлэнэ.

3.9. Шингэн зүйлс, тоос, шил, дугуйг хадгалах, хамгаалах, тээвэрлэхдээ Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар”-ын 5.7.2 дугаар бүлэгт заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

3.10. Хөнгөн зүйлүүдийг хатуу цаасан хайрцагт хийж, зохих хамгаалалтын материалаар хөдөлгөөнгүй болгоно. Түгээмэл эд ангиуд ба жижиг хэсгүүдийг ямар системд хамаарч байгааг нь тодорхой тогтооно. Хугарсан хэсгүүдээс гадна бүх хоорондоо таарч байгаа юм уу дагалдах хэсгүүдийг шалгуулахаар өгнө. Эд ангийн инженерийн зураг бэлэн байхгүй бол гэмтээгүй эд ангийг харьцуулах зорилгоор илгээнэ.

3.11. Эд ангиудыг эцсийн тээвэрлэлтэд бэлдэх үедээ тохирох хайрцаг сав ба шошго хэрэглэнэ. Тээвэрлэлтийн чиглэл нь товч бөгөөд тодорхой, тээвэрлэлтийн чухал асуудал ба бусад холбогдох нөхцөл байдлыг заасан байна.

3.12. Тээвэрлэлтийн явцыг тасралтгүй хянахад шаардлагатай гэж үзвэл тээвэрлэлтэд бэлдсэн ачаа, хайрцаг, савны фото зургийг авч, ачааны хөдөлгөөнийг бүртгэх дэвтрийг нээнэ.

3.13. Тээвэрлэлтийн зохион байгуулалтыг хийхдээ, эд ангиуд нь шинжилгээний лабораторид очихдоо ослын газар олдсонтой ижил нөхцөлд байх ёстой. Дараах зүйлүүдийг анхаар.

- Мөрдөж байгаа журам нь харуул хамгаалалтын шаардлагатай арга хэмжээг авсны дараа эд ангиудыг бүрэн бүтэн тээвэрлэх явдлыг баталгаажуулах ёстой.
- Жижиг эд ангиудад битүүмжилсэн давхар уут ба Албаны лацыг хэрэглэнэ.
- Утсан лац зэрэг шаардлага хангасан танигдахуйц лац хэрэглэнэ. Хөдөлгүүр ба сэнс зэрэг том эд ангиудад цоож хэрэглэнэ.
- Тээвэрлэлтийн компани нь дараахи шаардлагыг хангах ёстой.
- Найдвартай
- Нэр хүндтэй
- Тээвэрлэлтийн бүх үеүдэд ачааны аюулгүй байдал ба хамгаалалтыг хариуцах чадвартай
- Тээврийн компани нь дараах зүйлүүдийг эзэмшсэн байх ёстой.
- Тогтсон шаардлага хангахуйц бүртгэлийн систем
- Замын дагуу цоожтой, хамгаалалттай хашаа байшин юм уу эцсийн зогсоолын хадгалах байгууламж

3.14. Тухайн эд анги нь алдагдсан юм уу гэмтсэн тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаанд ноцтой саад учруулахаар шинжилгээний чухал ач холбогдолтой бол тухайн эд ангийг тусгай хамгаалагчаар хамгаалуулах, эсхүл шинжлэн шалгагч, ахлах шинжлэн шалгагчаас үүрэг авч, томилогдсон этгээд хариуцаж авч явна.

#### **Дөрөв. Осол, зөрчлийн нотлох баримтыг хадгалах**

4.1. Иргэний нисэхийн ажилтнуудын хамтын ажиллагааны хүрээнд Осол, зөрчлийг шинжлэн шалгах алба, Иргэний нисэхийн ерөнхий газар, цагдаагийн газар хамтран осол, зөрчлийн талаарх нотлох баримт, эд анги, бичиг баримтуудыг найдвартай хадгалах ёстой.

4.2. Осол, зөрчлийн эд мөрийн нотлох баримтууд нь алдагдах, чанар нь муудах болон гэмтэж болох тул фото зураг болон бусад шаардлагатай аргаар баримтжуулж авч хадгална.

4.3. Шинжлэн шалгах ажиллагаа болгонд цуглуулсан нотлох эд мөрийн баримтыг нарийн зөв тогтоох ба мэдээллийн алдагдал, бохирдол, чанарын муудалтыг багасгах журмыг хэрэгжүүлнэ.

4.4. Нотлох баримт болон бичиг баримтын бүртгэлд тухайн бичиг баримтыг хаана хэзээ хэрхэн олсон талаарх дэлгэрэнгүй мэдээллийг багтаана.

4.5. Шинжлэн шалгах эрх бүхий байгууллага нь осол, зөрчлийн нотлох баримт болон бичиг баримтын нууцлалыг хадгална.

4.6. агаарын хөлгийн осол, зөрчлийн түгээмэл нотлох баримтын тоонд Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар"-ын 5.7.2.5-ын iii бүлэгт заасан бичиг баримтууд орно.

4.7. Бичиг баримтыг дараах шалтгааны улмаас гэмтэхээс аль болох түргэн сэргийлэхийн тулд -18 хэм хүртэл хөргөнө.

- Барих
- Агаарт хатаах
- Биологийн задралд орох ба хөгцрөх

4.8. Усан дотроос олсон бичиг баримтыг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар"-ын 5.7.2.5-ын V бүлэгт заасны дагуу хадгалж тээвэрлэнэ.

4.9. Агаарын хөлгийн нислэгийн бодит хяналтын төхөөрөмжийг тээвэрлэхдээ бичлэг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар"-ын 5.7.2.7 бүлэгт заасан зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

4.10. Гэмтэл бэртлээс сэргийлэхийн тулд аюултай бараануудтай харьцах ба тээвэрлэх үед үргэлж мэргэжилтнүүдээс зөвлөгөө авна. Хөлдөөсөн материалыг тээвэрлэх үед "хуурай мөс"-ний аюул ба тээвэрлэлтийн журмын талаар мэддэг байх шаардлагатай.

4.11. Аюултай барааг тээвэрлэх үед баримтлах дүрэм, хязгаарлалт, анхааруулга, журмын талаар мэддэг байх шаардлагатай бөгөөд "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар"-ын 5.7-ын бүлэгт заасны дагуу аюулгүй байдлыг хангаж ажиллана.

4.12. Эд ангиуд болон хэсгүүдийг даавуу юм уу бусад тохиромжтой материалд ороож, нэмж гэмтэхээс сэргийлэн хайрцагт хийж хадгална.

4.13. Хүнд жинтэй эд ангиудыг ороож, хөдөлгөөнийг хязгаарлахад хангалттай баглаа боодолтойгоор тусад нь модон хайрцагт хийнэ.

## Тав. Нотлох баримтыг шинжилгээнд өгөх

5.1. Хэрвээ томоохон эвдрэл гарсан гэж үзэж байгаа боловч ослын газарт эд мөрийн баримтыг шинжлэх байгууламж ба мэргэжилтнүүд байхгүй бол эд мөрийн баримтыг тохирох байгууламж руу шалгуулахаар явуулна. Шинжилгээний үйлчилгээг зохион байгуулахын өмнө дараах зүйлүүдийг анхаарна.

- Хэмнэлт хийх үүднээс шаардлагатай баримтыг олж тогтоох ажлыг хамгийн боломжит хэмжээнд хязгаарлана.

- Албаны төв байртай ойролцоо байгууламжаас илүү бүс нутагт байрласан байгууламжийг ашиглах нь зүйтэй. Лабораторид шийдвэр гаргахын өмнө ерөнхий шинжлэн шалгагчтай зөвлөлдөх шаардлагатай.

- Эдгээр үйлчилгээг сонгох үедээ гарч болох эрх ашгийн зөрчлийг болгоомжтой тооцох шаардлагатай ба ийм асуудал байгаа бол түүнийг хурдан шуурхай байдал ба зардлаас илүү чухалчлах ёстой.

- Хэдийгээр зөв зорилготой боловч хангалтгүй мэдлэгтэй эсвэл шаардлага хангахгүй тоног төхөөрөмжтэй орон нутгийн мэргэжилтнүүд нь шалган шинжлэх оролдлого хийснээрээ үнэтэй эд мөрийн баримтыг устгаж болно гэдгийг анхаарах шаардлагатай.

- Шинжилгээний журам нь буруу юм уу тохиромжгүй байдлын улмаас гарсан баримтын алдааг залруулахын тулд шинжилгээ хийж байгаа газар нь шаардлага хангасан ба чадвартай гэдгийг батлах ёстой. Эргэлзээтэй үед лабораторийн чадварыг шалгатал хүлээнэ.

- Шинжилгээний зорилгоор задаргаа хийх тохиолдолд, ажиллагаа эхлэхээс өмнө түүний бүх талуудыг гүйцэтгэх боломжтой ба задаргаа хийсэн зүйлүүдийн шаардлага хангасан бүртгэл хийгдэнэ гэдгийг баталгаажуулах ёстой.

- Аливаа шалгалт нь холбогдох техникийн журамд нийцэж, үр дүнг нь хүлээн зөвшөөрөгдсөн форматаар хэвлэнэ гэдгийг баталгаажуулах ёстой.

- Мөн аливаа шалгалт нь эдгээр журамд нийцсэн бөгөөд хүлээн авч болохуйц тайлан хэвлэгдсэн гэдгийг батлах ёстой.

- Лабораторийн үйлчилгээ авахыг хүссэн зохих маягыг ашиглаж, шинжлэн шалгагчийн ажилд саад учруулах юм уу зүй бусаар хязгаарлахгүйгээр шалгалтын зорилгыг нямбай тодорхойлж бичнэ.

5.2. Эд ангийн нарийн зөв түүхийг өгөх ба үүнд дараах мэдээлэл орно.

- Суурилуулсан өдөр
- Нийт ашигласан цаг
- Их засвар ба үзлэгээс хойш өнгөрсөн хугацаа
- Эд ангийн бүртгэлийн картын хуулбар
- Өмнө нь мэдээлэгдэж байсан дутагдлууд
- Ямар нэг арай том хэсэгт багтаж байгаа бол том хэсгийнх нь тухай үндсэн мэдээлэл
- Бусад шаардлагатай мэдээлэл

5.3. Тээвэрлэлтийн гэрээлэгч талд хяналтын маягыг өгч, хүлээн зөвшөөрсөн гарын үсэг зуруулна. Эд анги, нотлох баримтыг хүлээн авснаас эхлээд өмчлөгчид нь буцаан явуулах хүртэл тухайн эд ангиудыг шалгах бүх ажиллагаанд шинжлэн шалгах эрх бүхий байгууллагын шинжлэн шалгагч нь биечлэн оролцох ёстой.

5.4. Эд ангиуд нь шинжлэн шалгах ажиллагаанд цаашид хэрэггүй гэж Алба үзсэн үед эд ангийг өмчлөгч буюу үйл ажиллагаа явуулагчийн хүсэлтэд боломжийн хирээр нийцүүлэн буцаах шаардлагатай арга хэмжээг авна.

5.5. Эд ангийг хүлээн авсан, буцаасныг бичгээр баримтжуулж, өмчлөгч буюу үйл ажиллагаа явуулагч хүлээн авсан бичигт дээр гарын үсэг зуруулна. Хавсралт №1-д маягтийг үзүүлэв.

5.6. Нотлох баримтыг Хавсралт №2-д үзүүлсэн маягтын дагуу бүртгэнэ.

5.7. Нотлох баримтыг Хавсралт №3-д үзүүлсэн маягтын дагуу холбогдох этгээдэд буцааж олгоно.

АГААРЫН ХӨЛГИЙН ЭД АНГИ, СЭЛБЭГ ХЭРЭГСЭЛ, НОТЛОХ  
БАРИМТЫГ ХҮЛЭЭЛЦЭХ ХҮСНЭГТ

Эзэмшигч	Төрөл, маяг	Нислэгийн нэр	Бүртгэлийн дугаар	Ангилал
<b>Байрлал</b>	<b>Огноо</b>	<b>Хүлээлгэн өгсөн</b>		
		Эд анги	Сэлбэг хэрэгсэл	
<b>Өгсөн Сэлбэгийн нэр</b>		<b>Part Number</b>	<b>Тэмдэглэл</b>	

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн дагуу би дээрх сэлбэг, эд ангийг тус албанд хүлээлгэж өгөв.

Эзэмшигч болон эзэмшигчийг төлөөлж:

Овог нэр \_\_\_\_\_ (гарын үсэг) \_\_\_\_\_

Хаяг \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Хүлээн авсан хүний нэр: \_\_\_\_\_  
(гарын үсэг) \_\_\_\_\_

Хүлээн авсан огноо: \_\_\_\_\_

Буцаан олголт:

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн дагуу би дээрх сэлбэг, эд ангийг ( \_\_\_\_\_ ) эзэмшигч болон ашиглагчид шинжлэн шалгах ажиллагаа дууссан тул буцааж хүлээлгэж өгснийг баталж байна.

Овог нэр \_\_\_\_\_  
(гарын үсэг) \_\_\_\_\_

Эзэмшигч болон эзэмшигчийг төлөөлж:

Овог нэр \_\_\_\_\_ (гарын үсэг) \_\_\_\_\_

Хаяг \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Буцааж өгсөн огноо: \_\_\_\_\_



АГААРЫН ХӨЛГИЙН ЭД АНГИ, СЭЛБЭГ ХЭРЭГСЭЛ, НОТЛОХ  
БАРИМТЫГ АГУУЛАХАД ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ, БУЦААЖ АВАХ БАРИМТ

Эзэмшигч	А/х-ийн маяг	Нислэгийн нэр	Бүртгэлийн дугаар	Ангилал
Байрлал	Огноо	Хүлээлгэн өгсөн		
		Эд анги	Сэлбэг хэрэгсэл	
Өгсөн эд анги, сэлбэгийн нэр		Part Number	Тэмдэглэл	

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн дагуу би дээрх сэлбэг, эд ангийг тус албаны агуулахад хүлээлгэж өгөв.

Эзэмшигч болон эзэмшигчийг төлөөлж:

Овог нэр \_\_\_\_\_ (гарын үсэг) \_\_\_\_\_

Хаяг \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Хүлээн авсан хүний нэр: \_\_\_\_\_

(гарын үсэг) \_\_\_\_\_

Хүлээн авсан огноо: \_\_\_\_\_

Буцаан олголт:

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн дагуу би дээрх сэлбэг, эд ангийг ( \_\_\_\_\_ ) эзэмшигч болон ашиглагчид шинжлэн шалгах ажиллагаа дууссан тул буцааж хүлээлгэж өгснийг баталж байна.

Буцааж өгсөн хүний нэр \_\_\_\_\_

(гарын үсэг) \_\_\_\_\_

Эзэмшигч болон эзэмшигчийг төлөөлж:

Овог нэр \_\_\_\_\_

(гарын үсэг) \_\_\_\_\_

Хаяг \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_

Буцааж өгсөн огноо: \_\_\_\_\_